



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 4/192

Арвайхээр

Г Хүнс, барааны төв захын үйл ажиллагаанд  
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “л”, 29.2, “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, барааны төв захын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс баруун, зүүн талын хаалгаар 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 2018 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл автомашин орохыг түр хугацаанд хориглож, худалдаа эрхлэгчдийн барааг ачсан автомашиныг оройны 19:00 цагаас хойш ачаагаа буулгаж байхаар зохицуулсугай.

2. Хүнс, барааны төв захын баруун талд худалдааны үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа чингэлгүүдийг албадан нүүлгэж, ачаа, тээврийн үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгслүүдийг “Арцат трейд” худалдааны төвийн баруун талын автомашины зогсоолд зогсоосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Замын цагдаагийн тасгийн дарга (Д.Гомбосүрэнжав), сумын Мал эмнэлэг үржлийн тасаг (Б.Ариунцэцэг), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Л.Ганзориг), холбогдох албан тушаалтнуудад тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ